



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 575

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,  
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 31,440,052.00 (гучин нэгэн сая дөрвөн зуун дөчин мянга тавин хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий нэгдүгээр хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн, 43,089,510.00 (дөчин гурван сая наян есөн мянга таван зуун арав) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Халиун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгө бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133002451  
26-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны дугаар сарын 1-ны өдрийн  
575 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

"ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр, марк                                                        | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад орсон он | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                          | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|---|----------------------------------------------------------------------------|-------------|------------|---------------------|-------------------------|-----------------------------------------------------------------------|-------------------------|
| 1 | Бүгд найрамдах Турк улсын ЭСЯ-ны барилга байгууламжийн гадна дулааны шугам | м.кв        | 82         | 1952                | 31,440,052.00           | 31,440,052.00                                                         | -                       |
|   | НИЙТ ДҮН                                                                   |             |            |                     | 31,440,052.00           | 31,440,052.00<br>(гучин нэгэн сая дөрвөн зуун дөчин мянга тавин хоёр) | -                       |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны... дугаар сарын...-ны өдрийн  
575 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**"ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР"**  
**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Хөрөнгийн нэр                                                              | Ашиглалтад орсон огноо | Хөрөнгийн үнэ (төгрөг)                                                  |
|-----|----------------------------------------------------------------------------|------------------------|-------------------------------------------------------------------------|
| 1   | Бүгд найрамдах Турк улсын ЭСЯ-ны барилга байгууламжийн гадна дулааны шугам | 2024                   | 43,089,510.00                                                           |
|     | <b>НИЙТ ДҮН</b>                                                            |                        | <b>43,089,510.00 (дөчин гурван сая наян есөн мянга таван зуун арав)</b> |